



**МОНГОЛ УЛС, АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК ХООРОНДЫН "АЙМАГ, СУМЫН БҮСЧИЛСЭН НОГООН ХӨГЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТЕЛБӨР"-ИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТЕСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хууль тогтоомжийн тесөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дугээр сарын 23-ны өдрийн хуралдааны 56 дугаар тэмдэглэл, Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаан, Төсвийн байнгын хорооны 2023 оны 1 дугээр сарын 19-ний өдрийн хуралдаан, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 1 дугээр сарын 19-ний өдрийн хуралдааны санал, дүгнэлт, Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 15 дугаар захирамжийг тус тус үндэслэн Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын "Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрт Сангийн сайд Б.Жавхлан 2023 оны 2 дугаар сарын 28-ны өдөр гарын үсэг зурсан.

"Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн зорилт, хамрах хүрээ, хийгдэх арга хэмжээ нь Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ын Аж үйлдвэржилт, Хот, хөдөө болон Ногоон хөгжлийн сэргэлтүүдийг дэмжих санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгоход чиглэгдсэн.

Түүнчлэн, Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын хүрээнд хүнсний сүлжээний бүх үе шатанд аюулгүй байдлыг бүрэн хангах, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлж, мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах, ашиг шимийг сайжруулах, үйлдвэрлэл, түүхий эдийн дотоодын нөөц ашиглалтыг нэмэгдүүлэхэд тус хөтөлбөр дэмжлэг үзүүлнэ.

Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын "Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн Санхүүжилтийн еренхий хэлэлцээр нь Олон улсын тэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтад заасан гадаад улс, олон улсын байгууллагаас авах зээлийн еренхий нехцэлийн тухай олон улсын гэрээ тул Улсын Их Хурлаар заавал соёрхон батлуулах шаардлагатай юм.

**Хоёр.Хууль тогтоомжийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн тесэл нь 1 зүйлтэй байх бөгөөд тус зүйлд Монгол Улс, Азийн хөгжлийн банк хооронд 2023 оны 2 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан "Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн Санхүүжилтийн еренхий хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгана.

**Гурав.Хууль тогтоомж батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын "Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн Санхүүжилтийн еренхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг баталснаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн ямар нэгэн серөг үр дагавар гарахгүй бөгөөд хөтөлбөр хэрэгжсэнээр хүн амыг амьдрахад тааламжтай хот, суурин газар (аймаг, сумын төв)-т тогтвортой, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон ногоон хөдөө, аж ахуйн бизнесийг хөгжүүлж, улмаар нүүрсхүчлийн хийн ялгарлыг багасган нутаг дэвсгэрийн ногоон хөгжил болон хот-хөдөөгийн холбоосыг бий болгох хөгжлийн загвар, хувьслыг дэмжих ач холбогдолтой.

**Дөрөв.Хууль тогтоомжийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээний тухай, Хууль тогтоомжийн тухай болон бусад хууль тогтоомжид нийцүүлэх бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль байхгүй болно.